



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/179

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 26 дугаар зөвлөмжийн дагуу Арвайхээр сумын зорилтот бүлгийн иргэдэд 2019 онд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах тендерийг 1 дүгээр багц 1, 2 дугаар баг, 2 дугаар багц 7 дугаар багийн зорилтод бүлгийн иргэдэд Эмт булаг ХХК, 3 дугаар багц 4 дүгээр баг, 5 дугаар багц 3, 8 дугаар багийн зорилтод бүлгийн иргэдэд Сод-Ээл ХХК, 4 дүгээр багц 5, 6, 13 дугаар багийн зорилтод бүлгийн иргэдэд Арвайн сор ХХК, 6 дугаар багц 9, 12 дугаар багийн зорилтод бүлгийн иргэдэд Оргих тас ХХК, 7 дугаар багц 10 дугаар баг, 8 дугаар багц 11 дүгээр багийн зорилтод бүлгийн иргэдэд Их-Өшгөг ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж, тайланг нэгтгэн танилцуулах, гэрээ гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100402